



**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 4/52

Улаанбаатар хот

**Зардал гаргах тухай**

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 43 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 375 жилийн ойд зориулсан "Спортлог - Улаанбаатар" бүх нийтийн өдөрлөгийг 2014 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Эзэн Чингисийн талбай дээр зохион байгуулсугай.

2. "Спортлог - Улаанбаатар" бүх нийтийн өдөрлөгийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Бүх нийтийн өдөрлөгийг зохион байгуулахад шаардагдах 11.324.000 /арван нэгэн сая гурван зуун хорин дөрвөн мянга/ төгрөгийг хуваарилагдсан төсвөөс зохих журмын дагуу гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Бүх нийтийн өдөрлөгийн урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж хөтөлбөрийн дагуу зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Tushaal 2014

1150500121